

A wide-angle photograph of a modern city skyline at dusk. In the foreground, a large, curved, multi-tiered amphitheater is illuminated with warm yellow lights. The tiers are made of concrete and have green grass growing between them. The background shows several tall, modern buildings, including one with "CAPSTRON BANK" visible on its facade. The sky is a mix of blue and orange, indicating sunset or sunrise.

**ТОГТВОРТОЙ
ХӨГЖЛИЙН ТАЙЛАН 2025**

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН МЭНДЧИЛГЭЭ



Практикал Даатгал ХХК-тай хамтран ажилладаг эрхэм харилцагч та бүхэнд энэ өдрийн мэндийг дэвшүүлье.

Манай компани анх үүсгэн байгуулагдсан цагаасаа эхлэн бүтээгдэхүүн, үйлчилгээгээрээ салбартаа манлайлагч нь байж, анхны онлайн даатгалын үйлчилгээ болон чанарын менежментийн ISO стандартыг нэвтрүүлэн, хот болон орон нутгийн бүх салбарууддаа хэрэгжүүлэн ажиллаж байна.

Даатгал нь нийгмийн эрсдэлийг тодорхой хэмжээнд хуваалцаж цаашид өөрөө хөгжих боломжоор нь хангаж өгдөг хамгийн буянтай бизнес юм. Бид зах зээлд эзлэх хувиа нэмэгдүүлэн нийт харилцагч даатгуулагч, хөрөнгө оруулагч байгууллагууддаа илүү хариуцлагатай, шинэлэг бүтээгдэхүүн үйлчилгээг технологийн дэвшилтэй хослуулан хүргэж байна.

2003 оноос идэвхитэй үйл ажиллагаагаа явуулж буй манай компани харилцагч та бүхний дэмжлэгтэйгээр чадварлаг боловсон хүчин өсгөж хөгжүүлэн өдрөөс өдөрт өргөжин тэлж, цар хүрээ, ололт амжилтаа бататган өнөөгийн хамгийн шилдэг даатгалын компаниудын тоонд зүй ёсоор орж байгааг дуулгахад таатай байна.

Өдрөөс өдөрт улам хурдацтайгаар шинэчлэгдэн өөрчлөгдөж буй амьдралын хэв маяг, бизнесийн орчны ахиц дэвшил, түүнд учирч болзошгүй эрсдэлийг удирдахад туслахыг бид ямагт хичээн ажилладаг бөгөөд харилцагч, даатгуулагчидтайгаа хамтдаа сурч, хамтдаа хөгжиж, эрсдэлгүй нийгмийн сайн сайхны төлөө нэгэн зорилготой, нягт холбоотой хамтран ажиллана гэдгээ илэрхийлье.

Эрхэм харилцагч, даатгуулагч та бүхний ажил үйлс өргөжин дэвжиж, аливаа эрсдэлээс ангид, ирээдүйд илүү итгэлтэй, амжилт бүтээл, аз жаргалаар дүүрэн байхын ерөөлийг өргөн дэвшүүлье!

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



Н.ТҮМЭНДЭМБЭРЭЛ

КОМПАНИЙН ТАНИЛЦУУЛГА

Практикал Даатгал ХХК нь 2003 онд үүсгэн байгуулагдаж, даатгалын салбарт тогтвортой үйл ажиллагаа явуулж ирсэн үндэсний компани юм. Өдгөө 21 аймагт 24 салбар нэгж, 200 гаруй төлөөлөгчтэйгөөр харилцагчдад ойр, хүртээмжтэй үйлчилгээ үзүүлж байна. Байгуулагдсан цагаасаа эхлэн салбарын шинэчлэл, инновацын чиг хандлагыг манлайлан, харилцагчдын хэрэгцээ шаардлагад нийцсэн чанартай бүтээгдэхүүн, үйлчилгээг тасралтгүй хөгжүүлэн хүргэхийг зорин ажиллаж байна.

Алсын хараа

Хүн төвтэй бүтээгдэхүүн үйлчилгээ, технологийн дэвшлээр дамжуулан ирээдүйдээ итгэлтэй, хамгаалагдсан мэдрэмжийг авахыг хүссэн хүн бүрийн тэргүүний сонголт нь болно.

Эрхэм зорилго

Ирээдүйгээ итгэл дүүрэн, зоригтойгоор угтах боломжийг хүн бүрд

Үнэт зүйлс

Харилцагч төвтэй

Хариуцлагатай

Тасралтгүй шинэчлэгч



60 тэрбум төгрөг

Нийт хөрөнгө



2.4 тэрбум төгрөг

Цэвэр ашиг



48 тэрбум төгрөг

Нийт хураамжийн орлого



22.6 тэрбум төгрөг

Нийт нөхөн төлбөр



ТОГТВОРТОЙ ХӨГЖИЛ БА БИДНИЙ ОРОЛЦОО

Практикал даатгал нь даатгалын бүтээгдэхүүн, үйлчилгээ болон өдөр тутмын дотоод үйл ажиллагаагаараа дамжуулан тогтвортой хөгжлийн зорилгуудад хувь нэмрээ оруулж, байгаль орчин, нийгэм, засаглалын эрсдэл ба боломжуудад үндэслэн бизнесийн бүхий л оролцогч талуудад ээлтэй, ашиг тустай ажиллахыг зорьдог.

Нэгдсэн менежментийн тогтолцооны бодлого

"Бид харилцагч бүрийнхээ хэрэгцээ шаардлагыг мэдэрч, үйл ажиллагаа тасралтгүй сайжруулан, тогтвортой хөгжилд хамтдаа тэмүүлнэ."

Практикал даатгал нь MNS ISO 9001:2013 Чанарын менежментийн тогтолцоо, MNS ISO 14001:2015 Байгаль орчны менежментийн тогтолцоо зэрэг стандартуудыг багтаасан **НЭГДСЭН МЕНЕЖМЕНТИЙН ТОГТОЛЦОО**-г батлан, хэрэгжүүлж байна.



Практикал даатгал ХХК нь Санхүү, даатгалын салбарт хамгийн анхны **ISO 14001:2015** байгаль орчны чанарын тогтолцоог нэвтрүүлсэн.



Практикал даатгал ХХК нь Санхүү, даатгалын салбарт хамгийн анхны **ISO 9001:2013** чанарын тогтолцоог нэвтрүүлсэн.



БАЙГАЛЬ ОРЧНЫ НЭГДСЭН МЕНЕЖМЕНТИЙН ТОГТОЛЦООГ НЭВТРҮҮЛЭН, ХЭРЭГЖҮҮЛСЭН **АНХНЫ ДААТГАЛЫН КОМПАНИ** БОЛЛОО.



БАЙГАЛЬ ОРЧИН

Ногоон даатгал

Ногоон байгууламж

Ногоон тогтолцоо

НОГООН ДААТГАЛЫН ЭРСДЭЛҮҮД

Практикал даатгал нь уур амьсгалын өөрчлөлт, байгалийн гамшиг, гал түймэр зэрэг байгаль орчны эрсдэл нь иргэд, аж ахуйн нэгжийн амьжиргаа, эдийн засгийн тогтвортой байдалд өсөн нэмэгдэж буйг харгалзан, эдгээр эрсдэлийг бууруулах, дасан зохицох санхүүгийн шийдэл бүхий даатгалын бүтээгдэхүүнүүдийг зах зээлд санал болгож байна.


Байгалийн эрсдэл

Байгалийн жам ёсны хүчин зүйлээс үүдэлтэй, хүний хяналтаас гадуур үүсдэг эрсдэл.

- Үер, ган, зуд
- Шуурга, салхи, мөндөр, аянга
- Газар хөдлөлт, нуранга
- Цас их орох, огцом хүйтрэлт
- Ой, хээрийн түймэр

Галын эрсдэл

- Гал түймэр
- Тэсрэлт, дэлбэрэлт
- Цахилгаан, дулааны шалтгаант гал



НОГООН ДААТГАЛЫН ХАМГААЛАЛТ

Практикал даатгал нь уур амьсгалын өөрчлөлт, байгалийн гамшиг, гал түймэр зэрэг байгаль орчны эрсдэл нь иргэд, аж ахуйн нэгжийн амьжиргаа, эдийн засгийн тогтвортой байдалд өсөн нэмэгдэж буйг харгалзан, эдгээр эрсдэлийг бууруулах, дасан зохицох санхүүгийн шийдэл бүхий даатгалын бүтээгдэхүүнүүдийг зах зээлд санал болгож байна.

Санал болгож буй даатгалын бүтээгдэхүүнүүд:

- Эрүүл мэнд, гэнэтийн ослын даатгал
- Авто тээврийн хэрэгслийн даатгал
- Хөрөнгийн даатгал
- Барилга угсралтын даатгал
- Ачаа тээврийн даатгал
- Малын индексжүүлсэн даатгал
- Бизнес тасалдлын даатгал
- Газар тариалангийн даатгал



Цахилгаан автомашины даатгал

Уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах, нүүрстөрөгчийн ялгаруулалтыг бууруулах үндэсний болон олон улсын зорилтуудтай уялдуулан, нүүрсхүчлийн хий ялгаруулалтыг багасгаж, агаарын бохирдлыг бууруулан экосистемийн тэнцвэрийг хадгалахад чухал үүрэгтэй цахилгаан автомашиныг дэмжих зорилгоор “Цахилгаан автомашины даатгал” шинэ бүтээгдэхүүнийг зах зээлд нэвтрүүлсэн.

НОГООН БАЙГУУЛАМЖ

2025 онд байгаль орчинд ээлтэй ажлын орчныг бүрдүүлэх, ажилтнуудын эрүүл мэнд, сэтгэл зүйн тав тухыг дэмжих зорилгоор төв оффисын газар, нэгжүүдийн дунд тасалгааны ургамал авчрах, арчлах аяныг амжилттай зохион байгууллаа. Ингэснээр хүчилтөрөгч ялгаруулалтын хэмжээ 3 дахин өсөв.

200 КГ
хүчилтөрөгч ялгаруулсан



Практикал даатгал нь тайлант онд **200** ширхэг мод суулгаж тарилаа.

Агаарын бохирдлыг бууруулах, хүлэмжийн хийн ялгарлын эсрэг ногоон байгууламж нэмэгдүүлэх зорилгоор жил бүр мод тарих хөтөлбөрийг хэрэгжүүлдэг.

НОГООН ТОГТОЛЦОО

Цахим даатгал

Практикал даатгал нь 2024 онд бүтээгдэхүүн борлуулалт болон нөхөн төлбөрийн материал бүрдүүлэх үйл явцыг **бүрэн цахимжуулсан** өөрийн вебсайтыг нэвтрүүлж, даатгалын үйлчилгээний хүртээмж, шуурхай байдлыг нэмэгдүүлсэн.

Одоогоор тус вебсайтаар дамжуулан 3 хэлбэрийн 6 даатгалын бүтээгдэхүүнийг борлуулж байгаа бөгөөд энэ нь харилцагчдад даатгалын үйлчилгээг илүү ойлгомжтой, хүртээмжтэй, цаг хугацаа хэмнэсэн байдлаар авах боломжийг бүрдүүлсэн.

Мөн түүнчлэн тээврийн хэрэгсэл, жолоочийн хариуцлага, эрүүл мэнд болон гадаад, дотоодод зорчигчийн гэнэтийн ослын даатгалын нөхөн төлбөрийн **материалыг цахимаар хүлээн авч байна.**





НИЙГЭМ

Нөхөн олговор

| Хүний нөөц


| Нийгмийн хариуцлага

НӨХӨН ОЛГОВОР

Даатгалын байгууллага нь иргэд, аж ахуйн нэгжийн санхүүгийн тогтвортой байдлыг хамгаалж, эрсдэлийн дараах сэргэлтийг дэмжих замаар нийгэм, эдийн засгийн тогтвортой хөгжилд хувь нэмэр оруулдаг.

Практикал даатгал нь сүүлийн гурван жилд олгосон нөхөн төлбөрийн дүнгээр даатгалын салбартаа **ТОП** байгууллага болохыг доорх графикаас харж болно.

Олгосон нөхөн төлбөрийн дүн



Практикал даатгал нь нийгэм, эдийн засгийн тогтвортой байдалд сөргөөр нөлөөлөх, хууль бус болон нийгмийн эсрэг шинжтэй аливаа үйл ажиллагааг дэмжихгүй байх зарчмын хүрээнд тодорхой даатгалын гэрээнд тодорхой эрсдэлийг нөхөн төлбөр олгохгүй нөхцөлөөр тусгаж өгсөн байдаг. Тухайлбал,

- Улс төрийн шинж чанартай үйл ажиллагааны улмаас үүдсэн хохирол
- Гэмт хэргийн шинжтэй үйл ажиллагааны улмаас үүдсэн хохирол
- Дайн, хувьсгал, маргаан булаан эзлэх, барьцаалах, баривчлан саатуулах, тэсрэх бөмбөг дэлбэрэх, террорист
- Асбест, силикатай холбоотой үүссэн хохирол
- Цахилгаан соронзон орны нөлөөллөөс үүссэн хохирол
- Газар доорх нөөц, тэдгээрийн алдагдал/хохирол
- Цөмийн эрчим хүчний эрсдэл
- Радио актив бохирдолд
- Биологийн болон химийн хортой материалтай холбоотой хохирол, эрсдэл

ХҮНИЙ НӨӨЦ

Практикал даатгал нь ажилтнуудын мэргэжлийн ур чадвар, ёс зүй, үйлчилгээний чанарыг тасралтгүй сайжруулахад анхаарч, шударга хөдөлмөрийг харилцаа, тэгш боломж, олон талт байдлыг дэмжсэн хүний нөөцийн бодлогыг хэрэгжүүлэхэд чиглэн ажилдаг.

Төлөөлөн удирдах зөвлөл



Удирдах албан тушаал



Нийт ажилчид



■ Эрэгтэй ■ Эмэгтэй

Өндөр настай ажилтан

9

Ажилчдын дундаж нас

30

Насны бүлгийн харьцаа



Суралт, хөгжил

Практикал даатгал компани нь ажилтнуудынхаа тогтвортой өсөлт, хөгжилтийг дэмжих зорилгоор дотоод болон гадаадын мэргэжлийн сургалтуудад тогтмол хамруулж, хүний нөөцийн чадавхийг бэхжүүлэхэд анхаарч ажилладаг.

ГАДААД:

- Япон улсад зохион байгуулагдсан "ISJ Advanced Course - Development of a Strategy for a Resilient and Sustainable General Insurance Business" сургалт

ДОТООД:

- Шинэ ажилчдад зориулсан тогтмол чиглүүлэх сургалт
- Удирдлагын манлайлал, удирдах арга барил
- Excel хүснэгт, дата-тай ажиллах чадвар, түргэн ажиллах гэх мэт

Сургалтад
хамрагдсан
ажилчдын тоо

111

Сургалтад
хамрагдсан
цаг

200



НИЙГМИЙН ХАРИУЦЛАГА



БОЛОВСРОЛ



Залуусын хөгжлийг дэмжих, даатгалын салбар дахь оюутнуудын оролцоог идэвхжүүлэх зорилгоор СЭЗИС-ийн оюутнуудын санаачилсан “Insurance Challenge” даатгалын төслийн тэмцээнийг ивээн тэтгэж, амжилттай зохион байгуулав.



Тусгай хэрэгцээт хүүхэд, залуусын унших, бичих, илэрхийлэх чадварыг дэмжих зорилготой “МИНИЙ МӨРӨӨДӨЛ” эсээ бичлэгийн уралдааныг уламжлал болгон дэмжиж, оролцогч хүүхэд бүрийг урамшууллаа.



Хүн бүрт даатгалын боловсрол олгох зорилгоор цахим хуудсаараа дамжуулан даатгалын мэдлэг түгээх, бүтээгдэхүүний давуу болон сул тал, онцлогийг тайлбарласан мэдээллийн постеруудыг тогтмол нийтэлдэг.

СПОРТ



2025-2026 оны улиралд үндэсний дээд лигийн сагсан бөмбөгийн “Selenge Bodons” багийг 500 сая төгрөгийн үнэ цэн бүхий санхүүгийн дэмжлэгээр ивээн тэтгэж, эрүүл мэнд, гэнэтийн ослын даатгалаар баг тамирчдыг хамгаалах боллоо.



Улаанбаатар Амазонс багийн тамирчдыг 2028 оны зуны олимп хүртэл 1,530,000,000 төгрөгийн хамгаалалттай гадаад аялал, спортоос үүдэлтэй гэмтэл, бэртэл, эрсдэлээс сэргийлэх иж бүрэн даатгалаар хамгаалахаар болов.



Ambassadors Golf Cup 2025 олон улсын гольфийн тэмцээнийг амжилттай ивээн тэтгэж, даатгалын салбарын ач холбогдол, гүйцэтгэх үүргийг оролцогч талууд болон олон нийтэд танилцуулав.

БАЙГАЛЬ ОРЧИН, ЭРҮҮЛ МЭНД



Байгаль орчныг хамгаалах, ногоон хөгжлийг дэмжих зорилгоор жил бүр зохион байгуулагддаг “Мод тарих үндэсний аян”-д идэвхтэй нэгддэг бөгөөд 2025 онд Үндэсний цэцэрлэгт хүрээлэнд 200 гаруй мод тарьсан байна.



НҮБ-ын Тогтвортой Хөгжлийн 13-р зорилго болох “Уур амьсгалын өөрчлөлтийн үр нөлөөг бууруулах” зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны хүрээнд Хаан Банк-аас зохион байгуулсан "Green Day" өдөрлөгт амжилттай оролцлоо.



Хамт олныхоо эрүүл мэндийг дэмжих зорилгын хүрээнд жил бүр томуугийн эсрэг дархлаажуулалтад ажилтнууд болон тэдний гэр бүлийн гишүүдийг хамруулж, эрүүл ажлын орчин бүрдүүлэхэд чиглэсэн урьдчилан сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлсэн.

НИЙГЭМ



МҮХАҮТ-аас Монгол Улсын нийгэм, эдийн засгийн хөгжилд бодитой хувь нэмрээ оруулж буй шилдгүүдийг шалгаруулан өргөмжилдөг “Энтрепренёр-2025” арга хэмжээний “Даатгалын Энтрепренёр” шагналын эзнээр тодорч, Хүрэл Меркури цомын эзэн боллоо.



Уул уурхайн компани, тухайн салбарын ажилтан бүрийн аюулгүй үйл ажиллагаа, эдийн засгийн тогтвортой байдлыг хамгаалах зорилгоор “Mining Week & MinePro Mongolia 2025” арга хэмжээнд оролцов.



“Safety Sharing” санаачлагын хүрээнд гэнэтийн аюул осол, бэртэл гэмтэл, цахилгааны аюулаас сэргийлэх зөвлөмжийг нийт 60 гаруй удаагийн цувралаар хүргэж, иргэдийн аюулгүй байдлыг сайжруулах, эрсдэлийг бууруулахад чиглэсэн мэдээллийг тогтмол хүргэсэн.



ЗАСАГЛАЛ

Компанийн засаглал

| Ёс зүй ба комплайнс

| Эрсдэлийн удирдлага

КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ

Практикал Даатгал ХХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөл (ТУЗ) нь хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг хангах, хөрөнгийн өгөөж үр ашгийг нэмэгдүүлэх, компанийн гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагаанд хяналт тавин, оновчтой чиглүүлгээр ханган ажиллахыг зорьдог

Практикал Даатгал ХХК-ийн ТУЗ-ийг хувьцаа эзэмшигчдийн хурлаар жил бүр томилдог.

ТУЗ-ийн дэргэд дараах хороод идэвхтэй үйл ажиллагаа явуулж байна.



Аудитын хороо




Нэр дэвшүүлэх, цалин урамшууллын хороо



Эрсдэлийн хороо

Тус хороод нь тус бүрийн чиг үүргийнхээ дагуу бодлогыг хэрэгжүүлэн компанийн удирдлагын баг болон компанийн үйл ажиллагаанд хяналт тавин дүгнэлт өгч, үр дүнгээ ТУЗ-д тайлагнан ажилладаг.



Эрсдэлийн хороо нь компанийн эрсдэлийн хүлцэл, болзошгүй эрсдэлийг тодорхойлж үнэлэн, түүнийг хянах дотоод хяналтын тогтолцоонд дүгнэлт, зөвлөмж өгдөг.

Аудитын хороо нь компанийн санхүү, дотоод хяналт, комплаенс болон эрсдэлийн удирдлагын тогтолцооны үр дүнтэй байдалд хяналт тавьж, хараат бус аудитын үйл ажиллагааг дэмжин чиглүүлдэг.

Цалин урамшуулал, нэр дэвшүүлэх хороо нь компанийн болон эрх бүхий албан тушаалтнуудын цалин, урамшууллын бодлого, гүйцэтгэл, залгамж халаа, гэрээний нөхцөлийг тодорхойлж, хэрэгжилтэд хяналт тавьж чиглүүлдэг.



ЁС ЗҮЙН ДҮРЭМ

Практикал даатгал нь тогтвортой хөгжлийн хүрээнд хууль, шударга ёсыг дээдэлсэн, ил тод, хариуцлагатай засаглалыг эрхэмлэн үйл ажиллагаагаа явуулдаг.

Компанийн бизнесийн ёс зүйн дүрэм нь ТУЗ, удирдлага, ажилтнууд, харилцагч, бизнесийн түншүүдэд адил тэгш үйлчилж, даатгалын зах зээлд мөрдөх ёс зүйн нийтлэг хэм хэмжээг хэрэгжүүлэхэд чиглэдэг.

Хууль, шударга ёсыг дээдлэх
Ил тод, хариуцлагатай үйл ажиллагаа
Харилцагчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хүндэтгэх
Мэдээллийн нууцлал, өгөгдлийн хамгаалалт
Шударга өрсөлдөөн, ёс зүйтэй бизнес
Ашиг сонирхлын зөрчлөөс ангид, авлига, хээл хахуульд үл эвлэрэх

КОМПЛАЙНС

Практикал даатгал нь харилцагч мөнгө угаах болон санхүүгийн гэмт хэрэгт өртөх эрсдэлээс хамгаалж, урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг зохион байгуулахыг зорин ажилладаг. Комплаенсийн үйл ажиллагааг дараах хүрээнд хэрэгжүүлж байна.

Харилцагчийг таньж мэдэх
Эрсдэлийг үнэлэх, хариу арга хэмжээ авах, дахин үнэлэх
Сэжигтэй гүйлгээг илрүүлэх, хяналт тавих, мэдээлэх

ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА

Практикал даатгал нь эрсдэлийн удирдлагыг Хамгаалалтын 3 бүсийн тогтолцоо, хүлээн зөвшөөрөх эрсдэлийн мэдэгдэл /Risk appetite statement/, хариу арга хэмжээний үйл явцын дагуу хэрэгжүүлдэг.

Хүлээн зөвшөөрөх эрсдэл/Risk appetite/-ийн хүрээнд байгууллагын стратеги, зорилтуудад нөлөө үзүүлж буй эрсдэлийг тодорхойлж, үр дүнтэй удирдахад оршино. Уг зорилгын хүрээнд бүх төрлийн эрсдэлүүдийн хүчин зүйлсийг тодорхойлж, түвшин бүрд тохирох арга хэмжээг авч, үр дагаврыг бууруулдаг.

Практикал даатгал нь “Хамгаалалтын гурван бүс”-ийн загвараар эрсдэлийг удирдах үүрэг хариуцлагуудыг тохиромжтой байдлаар хуваарилан эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлдэг.

Хамгаагалтын 3 бүсийн тогтолцоо

1-р бүс

Бизнесийн нэгжүүд, хуульч, бусад хороодууд

2-р бүс

Эрсдэлийн удирдлагын хэлтэс

3-р бүс

Хараат бус дотоод аудит, аудитор

